



ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2013 оны 03 дугаар сарын 18-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Сервер болон сүлжээний төхөөрөмж нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: ST-2013/01

Монголбанк нь эрх бүхий тендерт оролцогчоос ажлын хэрэгцээнд зориулан сервер болон сүлжээний төхөөрөмж нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна. Тендер нь дараах багцтай байна. Үүнд:

Багц 1.Сервер төхөөрөмж,

Багц 2.Сүлжээний төхөөрөмж,

Багц 3.Сүлжээний нууцлалын төхөөрөмж.

Тендерийн бичиг баримтыг бичгээр хвсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 50,000 (тавин мянган) төгрөгөөр худалдан авч болно. Тендерийн баримт бичгийн үнийг Монголбанкны 6115000100 тоот дансанд тушаана. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хвчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: 200,000,000.00 төгрөг,

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 250,000,000.00 төгрөг,

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2012, 2011 он.

Тендерийн хамт тендерт оролцохоор санал болгож байгаа үнийн дүнгийн 2 (хоёр) хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй бөгөөд тендерт оролцогчид давуу эрхийн зөрүү тооцохгүй болно. Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрнө.

Тендерийг 2013 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хвсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2013 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн бичиг баримт болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

МОНГОЛБАНК

Бага тойруу -3, 15160, Улаанбаатар хот,

Монголбанкны "А" байрны 1 давхар 2 тоот өрөө,

Утас: (976) 11-310633, 310150, Факс: (976)-11-311471